



СОЁМБОМ ЭДЭЭ

МОНГОЛ УЛСЫНХАА ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ!

187 /187/

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

2021.11.24

ЦАГ ҮЕ, ҮЙЛ ЯВДАЛ

ЖАНЖИН ШТАБЫН ДАРГА ХҮНДЭТ ЗОЧДЫГ ХҮЛЭЭН АВЧ УУЛЗАВ



ОХУ-ын Дорнод цэргийн тойргийн Агаарын довтолгооноос хамгаалахын болон агаарын цэргийн хүчний 11 дүгээр армийн командлагчийн орлогч, хошууч генерал Владимир Михайлович Куликов тэргүүтэй албаны хүмүүс манай улсад албан ёсны айлчлал хийж байна.

Уулзалтад Зэвсэгт хүчний Агаарын цэргийн командлагч, хошууч генерал О.Энхбаяр, БХЯ-ны ГХАГ-ын дарга, хурандаа Б.Бат-Эрдэнэ, АЦК-ын УНХ-ийн дарга, хурандаа Н.Очирбат, ОХУ-ын Дорнод цэргийн тойргийн Гадаад хамтын ажиллагааны хэлтсийн дарга, хурандаа Тараев Иван Степанович, Агаарын довтолгооноос

хамгаалахын болон Агаарын цэргийн хүчний 11 дүгээр армийн командлагчийн цэрэг-улс төрийн орлогч, хурандаа Сурьяков Сергей Викторович, ОХУ-ын Дорнод цэргийн тойргийн 266 дугаар дайрагч нисэхийн тусгай хорооны захирагч, хурандаа Малинин Денис Сергеевич болон албаны бусад хүмүүс оролцож, хоёр орны Зэвсэгт хүчний хамтын

ажиллагаа болоод цаашдын хамтын ажиллагааны талаар санал солилцсон юм. Дараа нь айлчлалын бүрэлдэхүүн Монгол ард эскадриль хөшөөнд цэцэг өргөж хүндэтгэл үзүүлээд Монгол Улс, ЗХУ-ын баатар, Монгол Улсын анхны сансрын нисгэгч Ж.Гүррагчаатай уулзалт хийж, Одон орон судлалын музейг үзэж сонирхлоо.

Түүхэнд энэ өдөр

1949 он.

БНМАУ ба ЗХУ-ын Засгийн газрын хооронд "ЗХУ-ын цэргийн сургуулиудад МАХЦ-ийн албан хаагчдыг сургах ба хангах зардлуудыг нөхөн төлөх журмын тухай" гэрээ байгуулав.

ЦАГ АГААР

УЛААНБААТАР

ӨДӨР	ШӨНӨ
-4	-20

ӨМНӨД СУДАН

ӨДӨР	ШӨНӨ
39	24

ВАЛЮТЫН ХАНШ

ВАЛЮТ	АВАХ	ЗАРАХ
USD	2,852.0	2,854.0
EUR	3,275.0	3,285.0
CNY	445.80	449.80
RUB	38.50	40.00
JPY	24.65	25.23
KRW	2.38	2.46

ЗУРХАЙ

2021.11.24 ЛХАГВА ГАРАГ /БИЛГИЙН ТООЛЛЫН 20/

ӨВЛИЙН ТЭРГҮҮН ШАРАГЧИН ГАХАЙ САРЫН ДӨРВӨН НОГООН МЭНГЭТЭЙ УЛААН ХУЛГАНА ӨДӨР

Үс засуулбал: Өлсөж ундаасна Наран ургах, шингэх: 08.11-17.06 Барилдлага: Үхэх Шүтэн барилдлага: Сэрэхүй Суудал: Гал

ДОРНЫН ЗУРХАЙ:

Бич жилтнээ аливаа үйлийг хийхэд ЗЕРЭГ сайн

Энэ өдөр луу, бич жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба могой, морь жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүштэй. Эл өдөр элдэв үйлд хянуур хандах хэрэгтэй ба ан, гөрөө хийх, мал, адгуус муулах, лусыг тахиx, хүүхэд үрчлэн авах, урлан бүтээхэд сайн. Улааны үйл, төлгө тавих, морь уралдах, сэтгэлд сэтгэй газар очиход муу.

Өдрийн сайн цаг нь хулгана, үхэр, туулай, морь, бич, тахиа болой. Хол газар яваар одогсод зүүн ураги мөрөө гаргавал зохистой. Үс шинээр үргээлгэх буюу засуулахад тохиромжгүй.

ТХЦК-ЫН АЛБА ХААГЧИД ЭЭЛЖИТ СУРГАЛТАД ХАМРАГДАВ

Зэвсэгт хүчний Тусгай хүчний цэргийн командлалын "Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, дэг журам, сахилга харууллагыг бэхжүүлэх салбар зөвлөл"-өөс харьяа нэгтгэл, ангиудын бие бүрэлдэхүүнтэй "Хувь хүний хөгжил, төлөвшил. Би хэн бэ?" сургалтыг энэ сарын 15-19-ний өдрүүдэд зохион байгууллаа.

Захирагчийн орлогч, ажиллагааны ахлагч нартай болон харьяа нэгтгэл, ангиудын бэлтгэгдсэн багш нар, нийт бие бүрэлдэхүүнтэй гэсэн хоёр үе шаттайгаар зохион байгуулж, нийт 590 цэргийн алба хаагчид хамрагдсан юм.

Ангийн эрүүл мэндийн төвөөс уг сургалт бэлтгэлийг явуулах орчин нөхцөлийг бүрдүүлж, оролцогчдыг коронавирусын халдвараас урьдчилан сэргийлэх, халдвар хамгааллын дэглэмийг сайтар сахиулах, өрөө тасалгааны ариутгал халдваргүйжүүлэлтийг сайтар ханган ажиллалаа.

ЦУГЛАРАЛТЫГ ЦАХИМААР ЗОХИОН БАЙГУУЛЛАА



Зэвсэгт хүчний Хуурай замын цэргийн 2021-2022 оны сургуулийн жилийн сургалтын төлөвлөгөөний дагуу нэгтгэл, ангиудын тагнуулын дарга, тагнуулын салбарын офицеруудтай явуулах заах арга зүйн цугларалтыг "Хуурай замын цэргийн нэгтгэл ангиудын тагнуулын дарга, офицеруудын мэргэжил, заах үр чадварыг дээшлүүлэх нь" сэдвээр цар тахлын нөхцөл байдалтай уялдуулан цахимаар зохион байгууллаа. Цугларалтаар Хуурай замын цэргийн штабын дарга, бригадын

генерал Л.Онцгойбаяр "Хуурай замын цэргийн тагнуулын өнөөгийн тулгамдаж буй асуудал" сэдвээр илтгэл тавьж хэлэлцүүлснээс гадна Цэргийн тагнуулын хэлтсийн дарга, хурандаа Б.Ганбат, Хуурай замын цэргийн тагнуулын дарга, хурандаа Б.Батмөнх, тагнуулын офицер, ахмад Я.Эрдэнэбилэг нар цугларалтад оролцогчдод мэргэжлийн бэлтгэл хичээлийг заах арга зүйн талаар тодорхой үүрэг даалгавар өглөө.

Ахмад Ц.ГАНБАТ

Зорилгодоо хурдан хүрэх 7 арга зам

1. Амьдралынхаа бүх талбарт юу хүсч байгаагаа нэгд нэгэнгүй тодорхойл. (эрүүл мэнд, гэр бүл, хайр дурлал, ажил төрөл, санхүү, боловсрол, хобби...)
2. Тодорхой болгосны дараа цаасан дээр буулгаж бич тэгээд бас дахин бич.
3. Зорилго биелэгдсэн байх эцсийн хугацааг товл. Хэрвээ том зорилго бол жижиг хэсэг болгон задалж, тус бүрт нь биелэгдэх хугацааг тодорхойл.
4. Зорилгын дагуу шууд хийх боломжтой зүйлийн жагсаалтыг гарга. Шинэ санаа төрөх болгондоо жагсаалтандаа нэмж оруул.
5. Түүрүүлж хийх зүйлүүдээ 1,2,3 гэж дарааллуулан бич.
6. Дарааллуулж бичсэн жагсаалтынхаа эхний үйлдлийг тэр даруй хийж эхэл. (энэ маш чухал алхам шүү!!!)
7. Эрч хүчээ хадгалахын тулд гаргасан зорилгын дагуу өдөр бүр үйлдэл хий!



МОНГОЛ УЛС ДАХЬ КОРОНАВИРУСИЙН МЭДЭЭ

НИЙТ БҮРТГЭГДСЭН
370.197 +509

ЭДГЭРСЭН
536,920

НАС БАРСАН
1,875 +7

ЦЭРГИЙН ТӨВ ЭМНЭЛЭГ

НИЙТ БАТЛАГДСАН
6459 +110

ХЭВТЭН ЭМЧЛҮҮЛЖ БУЙ
127

ЭДГЭРСЭН
6208

КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол
Нийт: 258,988,844

Эдгэрсэн
Нийт: 234,298,264

Нас барсан
Нийт: 5,182,246

Цахим шууданд

Г.ДАРАМЗАГД АГСНЫ НЭРЭМЖИТ ОЛОН УЛСЫН МЭРГЭЖЛИЙН ДУУ ДУУЛААЧДЫН УРАЛДААНЫ ШИЛДГҮҮД ТОДОРЛОО

Ц Д Б Э Ч - ы н алдартнуудын нэг, дуучин байлдагчаас офицер, найрал дууны хормейстер болтлоо өсөн дэвжсэн ажил амьдрал, уран бүтээлийн гайхамшигтай түүхэн замналтай хүмүүн бол алдарт хөгжмийн зохиолч Г.Дарамзагд юм.

Монголын дууны урлагт оруулсан түүний гавьяа зүтгэл, уран бүтээлийг алдаршуулан мөнхжүүлэх зорилгоор Г.Дарамзагдын нэрэмжит Олон улсын мэргэжлийн дуу дуулаачдын уралдааныг 2004 оноос эхлэн зохион байгуулж байгаа бөгөөд ЦДБЭЧ-ын уран бүтээлчид энэхүү уралдаанд тогтмол амжилттай оролцож ирсэн билээ.

2021 оны 11 дүгээр сарын 04-26-ны өдрүүдэд зохион байгуулагдаж буй байгаа Г.Дарамзагдын нэрэмжит Олон улсын мэргэжлийн дуу дуулаачдын IV уралдаанд



ЦДБЭЧ-ын уран бүтээлчид идэвх санаачилгатай оролцож, авьяас билгээ сорин өрсөлдөж, II шатны шалгаруулалтад 5 уран бүтээлч тунаан үлдсэнээс Гоцлол дуучин ахлах ахлагч МУСТА Б.Нарантунгалаг Г.Дарамзагд агсны нэрэмжит шагналыг хүртлээ.

Мөн өнөөдөр найрал дууны нэрт удирдаач Г.Дарамзагд агсны мэндэлсний 90 жилийн

ойд зориулсан эрдэм шинжилгээний хурлыг ойг тэмдэглэн өнгөрүүлэх комисс, эрдэмтэн судлаачид, ЦДБЭЧ хамтран Офицеруудын ордонд зохион байгуулж байна. Авьяас билэгт хөгжмийн зохиолчийн амьдрал уран бүтээлийн талаар шимтэн судлахаар зорьсон эрхэм хүмүүн та бүхнийг тус эрдэм шинжилгээний хуралд морилон саатахыг урьж байна.

ХУГАЦААТ АЛБАНЫ ДАЙЧДЫН ЭРХ ЗҮЙН МЭДЛЭГИЙГ ДЭЭШЛҮҮЛЭЭ



Зэвсэгт хүчний 327 дугаар анги

Энэ намар тус ангид шинээр татагдан ирсэн хугацаат цэргийн алба хаагчдын анхан шатны бэлтгэл сургалтыг явуулж, тэдэнд зориулсан уулзалт сургалт, соёл хүмүүжлийн арга хэмжээг дотооддоо

болон орон нутгийн байгууллагуудтай хамтран тасралтгүй зохион байгуулж байна. Тухайлбал, Дорнод аймгийн Тагнуулын газартай хамтран хугацаат цэргийн алба хаагчдын хууль, эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх сургалт явууллаа.

Уг сургалтаар Монгол Улсын Эрүүгийн хууль, цэргийн албаны эсрэг гэмт хэрэг, хар тамхи, мансууруулах бодисын хор нөлөө болон төрийн албаны нууцын тухай ойлголт, мэдээлэл өгч, харилцан ярилцав.

Ахмад Д.ГАНБААТАР

ГЭРЭЛ ЗУРГИЙН НЭГ АГШИН

Зэвсэгт хүчний 032 дугаар ангид 2021 оны 2 дугаар ээлжээр татагдан ирсэн шинэхан байлдагчид Эр цэргийн тангаргаа өргөөд анхны ёслол хүндэтгэлийн ажиллагаанд оролцож байгаа нь.

/ОХУ-аас Монгол Улсад албан ёсны айлчлал хийж буй төлөөлөгчид Монгол ард эскадриль хөшөөнд цэцэг өргөж буй арга хэмжээ/



Гэрэл зургийг ахлах ахлагч Г.БАТ-ЭРДЭНЭ

БЭЛТГЭЛ ОФИЦЕРЫН ЦОЛ ГАРДУУЛЛАА



Төв аймгийн ЗДТГ-ын Цэргийн штаб

Зэвсэгт хүчний Жанжин штабын даргын 2021 оны Б/1651 тоот тушаалаар бэлтгэл дэслэгч цол олгогдсон төрийн албан хаагчдад цол, батламжийг гардуулах ёслолын ажиллагааг Төв аймгийн ЗДТГ-ын Хүндэтгэлийн өргөөнд зохион байгуулж, ЗДТГ-ын дарга бөгөөд Цэрэг татлагын товчооны дарга С.Магнайбаяр, Цэргийн штабын дарга, дэд хурандаа Т.Төмөрчөдөр нар



цол, батламжийг гардуулж, алба хаагчдад баяр хүргэж, цаашдын нь ажил албанд амжилт хүслээ.

Төв аймгийн Сүмбэр, Дэлгэрхаан, Эрдэнэ, Зуунмод, Сэргэлэн, Өндөрширээт, Жаргалант сумдын эдгээр төрийн албан хаагчид Батлан хамгаалахын сайдын 2020 оны н/03 дугаар тушаалаар I шат буюу цахим сургалт, II шат буюу Үндэсний Батлан Хамгаалахын Их сургуулийн Мэргэжлийн сургалтад тус тус хамрагдан, амжилттай суралцан төгссөн юм.

ХҮЧИТ 32 БӨХИЙН БАРИЛДААНТАЙ, ТӨРСӨН ӨДӨРТЭЙ ЦЭРГИЙН ТАНГАРГИЙН БАЯР

Зэвсэгт хүчний 032 дугаар анги

Даваа гарагт зохион байгуулагдсан Цэргийн тангараг өргөх арга хэмжээний үеэр Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар Зэвсэгт хүчний 100 жилийн медалиар ахлах ахлагч М.Мөнхбаяр, ахлагч Б.Бат-Эрдэнэ нар, Батлан хамгаалахын сайдын тушаалаар "Дайчин алдар III" медалиар ахлагч А.Биндэрьяа, "Эх орны төлөө II" хүндэт тэмдгээр ахлах дэслэгч Т.Дэлгэрмаа нар шагнагдаж, албан тушаалын зэрэглэлийн "Ахлах дэслэгч" цолыг дэслэгч Т.Санжаасүрэн, О.Галбадрах, А.Ууганбаяр нарт олголоо.

Энэ үеэр дэслэгч Н.Хорлоо захирагчтай ХХТР-ын II салаа "Тэргүүний шилдэг салаа", III салааны байлдагч М.Сугарсүрэн "Онц сурлагатан", IV салааны байлдагч Б.Зоригт "Онц буудагч", II салааны байлдагч Д.Мөнхдэмбэрэл "Тамирчин дайчин" болж, бусдыгаа манлайлан шилдгүүдээр шалгарлаа.

Энэ өдөр 10, 11 дүгээр сард төрсөн 30 цэргийн төрсөн өдрийг тэмдэглэж, МУСТА ахлах



ахлах Н.Дашзэвэг "Төрсөн өдрийн дуу", II салааны байлдагч Б.Хангайгийн ээж МУГЖ Д.Ганцэцэг "Бэрдээ унших" шүлгээр дайчдад мэндчилгээ дэвшүүлэн бэлэг бариллаа.

БЗД-ийн ЗДТГ-ын Цэргийн штабын дарга, дэд хурандаа О.Энх-Амар дайчдад баяр хүргэж, "Цэргийн алба гэдэг чинь хүнийг эх оронч үзэлтэй, тэсвэр хатуужилтай болгон төлөвшүүлдэг хамгийн бахархалтай сайхан алба юм шүү" гэж захиад, цэргийн гал тогооны тогооч Т.Жазвандагма, Н.Бямбаа нарт "Чадамжийн гэрчилгээ", ангийн эрүүл мэндийн төвд агаар цэвэршүүлэгч

гардуулан өглөө. Мөн байлдагч Ц.Чингүүнжавын ээж Т.Алтантогос "Эрүүл байх эрхэм баян" хэмээгээд 14 хайрцаг нэг удаагийн маск, 10л гар ариутгагч /236мл/ зэргийг бэлэглэвээ.

Тангаргийн баярын төгсгөлд хүчит 32 бөхийн барилдаан зохион байгуулж, дайчид уран мэхийг уралдуулж, хүчийг үзэн барилдсанаас ХҮТР-ын V салааны байлдагч Э.Баасанжав түрүүлж, ХХТР-ын III салааны байлдагч С.Бат-Эрдэнэ үзүүрлэж, ХҮТР-ын V салааны байлдагч Э.Наранцацралт, ХХТР-ын II салааны байлдагч А.Угтахбаяр тусгай байруудад шалгарсан юм.

